

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2022 оны 05 дугаар сарын мэдээ

2022.05.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит 3 дугаар хуралдааныг хуралдуулж, сумын 2022 оны төсвийн тодотголыг хэлэлцэн баталлаа.

Мөн ГХУССЗ-өөс “Архигүй Баяндэлгэр” аяныг албан газруудын дунд 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 01 өдөр хүртэл зохион байгуулж байна.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 31 албан бичиг ирсний 18 нь хариутай, 13 –нь хугацаандаа, 5–нь хугацаа болоогүй байна.

2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/60 тоот захирамжаар 2022 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлгыг зохион байгуулсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Сумын засаг даргын захирамжийн дагуу “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг зохион байгуулж байна.

2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/74 тоот захирамжаар Сумын хэмжээний нийт өрхийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх тохижилт бүтээн байгуулалт, ногоон байгуулж хог хаягдал, ажлын шинэ санал санаачлагыг дэмжих замаар иргэдийг ая тухтай таатай орчинд ажиллах амьдрах нөхцлийг бүрдүүлэх, мөн 2022 оныг “Тохижилт, бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбоотойгоор “Хашаандаа сайхан амьдарцгаая, болзолт уралдааныг 05 дугаар сарын 18-ны өдрөөс 11 дүгээр сарын 01 ний өдрийг хүртэлх хугацаанд хоёр үе шаттай зохион байгуулж байна.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон орон нутагт үүссэн зарим нөхцөл байдал хүлээгдэж буй гүйцэтгэл зэргийг үндэслэн аймгийн ИТХурал 2022 оны 05 сарын 16 нд хуралдаж, 2022 оны төсвийг өөрчлөн баталсаны дагуу 2022 оны 05 сарын 25 -нд сумын ИТХ-ын төлөөлөгчид хуралдаж сумын 2022 оны төсвийн тодотголыг хэлэлцэн баталлаа.

Дээрх өөрчлөлтийн хүрээнд аймгийн төсвөөс сумдын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын үйлчилгээний албан хаагчдын эхний 4 сарын гүйцэтгэлийг хассан дүнгээр, мөн ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг улсын төсвөөс хорогдуулсан дүнгээр тус тус тооцоолон бууруулж баталсан.

- 2022 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

- Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг , тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилт хуваарийн дагуу эхний 4 сар бүрэн олгогдсон.

- Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн .

- Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. 2022 оны Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явагдахтай холбогдуулан бэлтгэл ажил хийгдэж байна,

- Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Төсөвт газрын нягтлан бодогч, нярав нар аймгийн өмчийн газраас зохион байгуулсан “Эд хөрөнгийн улсын тооллого” сургалтанд хамрагдаж заавар зөвлөгөө авч тооллогын бэлтгэл ажил явагдаж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Төрийн албан хаагчийн ёс зүй, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар төрийн албан хаагчдад болон багийн иргэдийн нийтийн хурлаар сургалт мэдээллийг зохион байгуулж ажиллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургууль: Олон улсын PISA үнэлгээнд улсын хэмжээнд нийт 196 сургууль /7300 сурагч/ сонгогдсоноос Сүхбаатар аймагт 4 сургууль сонгогдсон. Сонгогдсон суралцагчид математик, байгалийн ухаан, унших, бүтээлч сэтгэлгээний даалгаварыг 2 цаг, сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох асуулгыг 40 минутын хугацаанд хийж гүйцэтгэнэ. Энэхүү үнэлгээ 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Баяндэлгэр сумын ЕБСургуульд үнэлгээний хорооны гишүүн ирж өглөөний 09 цагаас оройн 21 цаг хүртэл 10,11 дүгээр ангийн 15 насны 42 сурагчид амжилттай шалгагдлаа.

04 сарын 18-наас 04 сарын 22 өдрийг хүртэл Ерөнхий боловсролын сургууль дээр зохион байгуулагдсан “САЙН БАГШИЙН-САЙН ТЕХНОЛОГИ” ур чадварын уралдааны I шатанд тэнцсэн Бага ангийн багш А.Сэрээтэр, НУЗАН-ээс МХУЗ-ын багш Р.Дэлгэрцогт, БУЗАН-ээс Математикийн багш Б.Эрдэнэсүвд нар тус тус тэргүүн байрыг эзлэж Сүхбаатар аймагт ур чадварын 2-р шатанд оролцохоор боллоо. Биеийн тамирын багш Б.Даваажаргал 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 01 хүртэл Улаанбаатар хотноо “ХҮЧ ЦОМ” Жудо бөхийн тэмцээнд амжилттай оролцлоо.

Биеийн тамирын багш Б.Даваажаргал 05 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 09 хүртэл Улаанбаатар хотноо “УАШ Жудо бөх”-ийн тэмцээнд амжилттай оролцлоо.

Үндэсний бичиг соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, эх хэлээ дээдлэх, сурлагын хоцрогдол арилгах, үндэсний бичгээр алдаагүй зөв бичих чадварыг сайжруулах зорилгоор Хэлний бодлогын зөвлөлөөс "Зөв бичигтэн" шалгаруулах уралдаан зохион явуулав. Уг уралдаанд 6-12 дугаар ангийн 213 сурагч оролцов.

Үндэсний бичиг соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, эх хэлээ дээдлэх, төрийн албан хаагчид болон иргэдийн үндэсний бичгээр алдаагүй зөв бичих чадварыг сайжруулах зорилгоор Хэлний бодлогын зөвлөлөөс "Зөв бичигтэн" шалгаруулах уралдаан зохион явуулав. Уг уралдаанд 39 албан хаагч оролцсоноос :

Тэргүүн байр: А.Заяа /англи хэлний багш /

Дэд байр: Д.Амаржаргал /бага боловсролын багш /

Гутгаар байр: С.Адъяа /бага боловсролын багш /

Тусгай байр: Д.Мөнхнасан /бага боловсролын багш /

Тусгай байр: Б.Жаргалсайхан /бага боловсролын багш /нар эзлэв.

Үндэсний бичиг соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, өдрийн хүрээнд Хэлний бодлогын зөвлөлөөс “Эх хэлний өдөр”-ийг 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэв.

2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 12Б ангийн сурагч С.Бадамханд “Надад мөрөөдөл бий” анхны бие даасан тоглолтоо хийлээ.

2022 оны 05 дугаар сарын 11-ны өдөр ЕБС-ийн захирал Т.Мажигсүрэн 9 болон 12 дугаар ангийн эцэг эхийн зөвлөлийн дарга нартай уулзан БСУГ-аас ирсэн чиглэл, зөвлөмжийг танилцууллаа.

2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Сүхбаатар аймгийн 3-р сургуулийн Байгалийн ухааны нэгдлийн хамт олон ЕБС-д ирж туршлага солилцон, ажлын түгээн дэлгэрүүлэлт хийлээ.

Технологийн хамтарсан хичээл болон Биологийн хичээлийг 8а, 8б ангиудад зааж, 7-9 дүгээр ангийн сурагчдад тамхины хор хөнөөлийн талаар сургалтыг зохион байгуулсан ба математикийн багш У.Чинзориг Математикийн хичээлийн ЭЕШ-д бэлтгэх аргыг 12 дугаар ангийн сурагч болон багш нарт танилцуулан туршлагаа хуваалцлаа.

Соёл: “Сүхбаатар-80” урлагийн наадамд 40 хүний бүрэлдхүүнтэй баг “Буян төгөлдөр-Баяндэлгэр” тоглолтоор амжилттай оролцож ардын авьяастан Д.Пүрэвсүрэн гоцлол хөгжмийн төрөлд тэргүүн байр эзэллээ.

6 багт өдөрлөг зохион байгуулж ард иргэдэд соёл урлагийн явуулын үйлчилгээ үзүүлж байна. Багийн өдөрлөгөөр соёл урлагийн үйлчилгээ, явуулын номын сан, соёлын өвийн тухай мэдээлэл сурталчилгаа, угийн бичгийн сургалт зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж байна.

Соёлын төвийн номын сан нь ажлын 8 цагаар тогтмол ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож ажиллаа.

5 дугаар сард байнгын уншигч 32, ирэгсэд 143 хүнд 163 ном гэрээр олгож 13 хүнд утсаар болон амаар лавлагаа өгч 11 татгалзал бүртгэлээ.

Судар эгшиглэн төслийн оролцогч хүүхдүүдийн уншсан номын тэмдэглэлийг үзэж заавар зөвлөмж өгч ажиллаа.

Судар эгшиглэн -2022 уралдааны 2-р шатанд оролцогчдын уншсан номын тэмдэглэлийг “Судах эгшиглэн-2022”, болон Баяндэлгэр Соёлын төв группэд постолж уншигчдаа сурталчиллаа.

Баяндэлгэр Соёлын төв цахим группт уран зохиол-2022, соёлын өв-2022, судар эгшиглэн-2022, дотоод үйл ажиллагаа-2022 булангуудыг хөтлөн нийт 33 мэдээлэл орууллаа.

Монгол улсын Их хурлын дарга Г.Занданшатарын ивээл дор “Илүү их уншъя” уриатайгаар зохион байгуулагдсан 31 дэх удаагийн баярын ажлын хүрээнд аймгийн СУГ, Нийтийн номын сангаас зохион байгуулсан нэгдсэн үйл ажиллагаанд оролцож өөрийн номын сангийн фондонд хадгалагдаж буй ховор ном баримтат өвөөр үзэсгэлэн гаргаж, сум сургуулийн номын сангийн түүхэн замнал үйл ажиллагааны талаар сурталчиллаа.

Мөн Баяндэлгэр сумаас төрөн гарсан зохиолч сэтгүүлчдийг цахим хэлбэрээр олон нийтэд таниулан сурталчилах үйл ажиллагааг зохион байгуулсаны үр дүнд Аймгийн нийтийн номын сангаас зохион байгуулсан “Оны шилдэг ном” шалгаруулах цахим номинацид Г.Баатарнумын “Богц дүүрэн инээд” ном “Оны шилдэг зохиолч яруу найрагч” цахим номинацид яруу найрагч У.БУД нар шалгарлаа.

Цэцэрлэг: Сумын эрүүл мэндийн төвийн эмч Г.Амартуяа, А.Лхамсүрэн нар ирж урьдчилан сэргийлэх үзлэг хийж мөн дархлаа дэмжих А витаминьг 2-4 насны 112 хүүхдийг витаминжуулсан. Эх хэлээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах ажлын хүрээнд манай хамт олон Байгууллагынхаа гаднах хаяг, багш ажилчид энгэрийн тэмдэгээ монгол бичгээр болгож шинэчилсэн. Мөн “Үндэсний бичиг дээдлэгч иргэн”-ээр бүлгийн багш Д.Амаа шалгарсан.

Сүхбаатар аймгийн ширээний теннисний 34 удаагийн аварга МУ-ын спортын дэд мастер Ц.Наранцэцэгийн нэрэмжит СӨБ-н байгууллагуудын багш ажилчдын

дунд зохион байгуулсан тэмцээнд багш Я. Отгонжаргал У.Ганзориг нар оролцож Залт 1мөнгө медалийн эзэд болж амжилттай оролцсон.

Тэр бум мод хариуцлагын гэрээний дагуу манай хамт олон нэгдэж эцэг таван хошуу малын хөшөөнд 250 ширхэг хайлаас, мөн байгууллагынхаа өөрийн эзэмшлийн хашааг өргөтгөн 347,76м² тэлж улиас 37 ширхэг, хайлаас 147 ширхэгийг суулгаж, шинээр хашаажуулсан.

Эцэг таван хошуу малын хөшөө болон зүүн талын сааданд суулгасан модныхоо ойр орчмын хог, чулууг цэвэрлэлээ.

Байгууллагынхаа гадна хог ангилах савыг хийж хог хаягдлын боловсролыг бага наснаас нь олгож, хогоо ангилж сурах, хогоо саванд хийдэг зөв иргэнийг төлөвшүүлэхэд зориулан хийсэн. Зарцуулсан мөнгөн дүн 2.500.000 төгрөг. Бэлтгэл бүлэг төгсөх сурагчид тайлант өдөрлөгөө 5 дахь өдөр зохион байгуулах гэж байна.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Сумын засаг даргын захирамжын дагуу “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг сумын хэмжээнд дараах байдлаар зохион байгууллаа.

Сумын ЗДТГ-ын хамт олон “Соёл амралтын хүрээлэн”-ийн хашаанд 1000 ш хайлаас, 250 ш Улиас тариж, усалгаа арчилгааг хийж ажиллаа. Мөн өмнөх жилийн модны цэнэг усалгааг графикийн дагуу хийж гүйцэтгэж байна.

Мөн Хөдөлмөр халамжийн газраас “Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр орон нутагт ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн халамжид хамрагддаг хөдөлмөрийн чадвартай 20 иргэнийг ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, мод тарих арчлах ажилд ажиллуулж байна.

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг суманд хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улиас 1 300, Хайлаас 2 000, Улаан сухай 100, Шар хуайс 200 нийт 3 600 модыг тарьсан байна. Мод тарих ажлын зардалд 13 000 000 /арван гурван сая/ төгрөг, Ногоон байгууламжийн 1 200 метр шинэ хашааны зардалд 12 000 000 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөө аж ахуй: Сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 1 дэх өдөр ХХААХҮЯ –нд программд шивж илгээдэг.

2022 оны 05 дүгээр сарын 23 -ны байдлаар сумын жишсэн дундаж хүн амын хоногийн хэрэгцээнд харьцуулснаар гурил – 65 хоног, гурилан бүтээгдэхүүн – 4 хоног, төрөл бүрийн будаа – 65 хоног, хуурай сүү – 26 хоног, өндөг – 3 хоног, ургамлын тос – 11 хоног, төмс – 11 хоног, хүнсний ногоо – 2 хоног, элсэн чихэр -22 хоног, давс – 65 хоног, ус – 4 хоногийн нөөцтэй байна.

Стандарт хэмжил зүйн ахлах мэргэжилтэнтэй хамтран хүнсний дэлгүүр, Эрүүл мэндийн төв, шатахуун түгээх станцын жин хэмжүүр, хэмжих хэрэгслийг баталгаажуулж, мөн зоогийн газар, хүнсний дэлгүүрүүдийн тохирлын гэрчилгээний хугацааг 2 жилээр сунгасан.

Өрхийн тариаланчийг дэмжиж “ **Хүлэмж**” төслийг хэрэгжүүлж “ 50 % -ийн хөнгөлөлттэй нөхцөлөөр 3 байгууллага, 13 иргэнд зуны хүлэмж нийлүүлсэн. Тухайн сард СХС-ийн зээл, зээлийн хүүгийн орлого 1,622,0 сая төгрөг төвлөрсөн.

Мал төллөлт, бойжилт, том малын хорогдлын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр ХХААГазарт, сар бүрийн эцэст статистикийн хэлтэст программд шивж

орууллаа. Том малын хорогдол бүгд 240, тэмээ – 1, адуу- 5, үхэр- 16, хонь- 109, ямаа- 109 нийт малын 0,05% нь хорогдсон байна. Мал төллөлт бүгд 176646, ингэ- 146, гүү- 4529, үнээ- 5849, эм хонь- 104199, эм ямаа- 61923 буюу нийт малын 76,74% төллөсөн байна.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн